


## Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны хагас жилийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан

Байгууллагын хэмжээнд 2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 117 өргөдөл, гомдол ирснээс, хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 100, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 17, судлагдаж байгаа 9 өргөдөл, гомдол байна. Захиргааны хэлтэст 19, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 38, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 59 өргөдөл, гомдол цохогдсон байна. Өргөдлүүдийн дамжин ирсэн эх үүсвэрүүд НҮНТ-д бүртгэсэн 3, ННЗБ 14, 1800-1200 дугаараас ирсэн 66, 11-11 төвөөс ирсэн 24, гар утасны аппликейшнээр ирсэн 1, фэсбүүк 3, eservice 3 нийт 117 өргөдөл, гомдол ирсэн байна. Мөн байгууллагад цаасаар ирсэн өргөдөл, гомдлыг скайрнердаж [egr.ulaanbaatar.mn](http://egr.ulaanbaatar.mn)-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.


Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 5 хоногт багтаан шийдвэрлэсэн 31, 10 хоногт багтаан шийдвэрлэсэн 23, 15 хоногт багтаан шийдвэрлэсэн 25, 30 хоногт багтаан шийдвэрлэсэн 30 хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 17 өргөдөл байна. 2020 оны 2 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 23 цаг 5 минут байгаа нь түрүү жилийн хагас жилтэй харьцуулбал 1 хоног 4 цаг 19 минут болж багассан үзүүлэлттэй байна. Иймээс цаашид өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хоногийг бууруулах төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийг 15 хоногт нийт өргөдөлийн 50% шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна

Хүснэгт 1



- 2 дугаар улирлын байдлаар өргөдөл гомдлын хандалтыг 2019 он- харьцуулвал Агаарын бохирдлын тухай өргөдөл гомдол 29.72 % багассан, түлшний эрэлт нэмэгдсэнтэй холбогдуулан сайжруулсан түлшний талаар өргөдөл гомдол 50.14% нэмэгдсэн байна. Нүүрсний зөвшөөрөл худалдаа болон бусад өргөдөл гомдол 12.64 % багассан үзүүлэлттэй байна.

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ХАНДАЛТ



Байгууллагын 7 хоног тутамд болдог шуурхай хуралд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн мэргэжилтнүүд тухай бүр нь анхааруулан дахин алдаа гаргахгүй сануулж байна. Цаашид өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүргэх төлөвлөн, зөрчил дутагдлыг багасгахаар төлөвлөн ажиллаж байна.

ХЯНАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.АЛТАНГЭРЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН: АРХИВ, БИЧИГ

ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Э.БЯМБАЦЭЦЭГ